



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/102

Чингис хот

Тусгай зөвшөөрөл сунгах, түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, 6 дугаар зүйлийн 6.2, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах, ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дараах аж ахуйн нэгжүүдийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаатай сунгасугай.

Хүнсний дэлгүүр:

- |                      |                            |
|----------------------|----------------------------|
| 1. Баянхутаг сум     | “Жаргалант онон тулга” ХХК |
| 2. Дадал сум         | “Гэгээн итгэл” ХХК         |
| 3. Бэрх тосгон       | “Зосын овоо” ХХК           |
| 4. Мөрөн сум         | “Түмэн богц” ХХК           |
| 5. Цэнхэрмандал сум  | “Цэлмэг цэнхэр” ХХК        |
| 6. Батноров сум      | “Мөнхжин бадрах” ХХК       |
| 7. Өмнөдэлгэр сум    | “Буян ундрах хэнтий” ХХК   |
| 8. Хэрлэн сум        | “Дэвжих тамир” ХХК         |
| 9. Хэрлэн сум        | “Сариг гол” ХХК            |
| 10. Хэрлэн сум       | “Хан оргил хишиг” ХХК      |
| 11. Хэрлэн сум       | “Золбоот хэрлэн” ХХК       |
| 12. Батноров сум     | “Ундран өсөх” ХХК          |
| 13. Цэнхэрмандал сум | “Оргилуун баян зам” ХХК    |
| 14. Хэрлэн сум       | “Ерөн ес хоршоо”           |

231010316

2.

Баар:

15. Цэнхэрмандал сум "Гансоёмбо" ХХК

16. Хэрлэн сум "Цэнэ трейд" ХХК

Зоогийн газар:

17. Хэрлэн сум "Гантэгш" ХХК,


18. Хэрлэн сум "Хааны алтан ураг" ХХК

2. Хэрлэн сумын "Хатан улз" ХХК-ний хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг түр хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэхэд хяналт тавих аймгийн комиссын дарга /Ц.Чогсомжав/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Б.Батсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /С.Сүнгээ/, Стандарт, хэмжилзүйн хэлтэс /Ч.Пүрэвдорж/, Татварын хэлтэс /А.Гантөмөр/, холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд албан ёсоор гардаж авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ